



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2019 оны 8 сарын 28 өдөр

Дугаар 250

Улаанбаатар хот

Нэр бүхий 10 үнэт цаасны компанийн үнэт цаасны зах зээлд зарим мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 8.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Энэхүү тогтоолын хавсралтад дурдсан нэр бүхий 10 үнэт цаасны компанийн холбогдох мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 8 дугаар сарын 28-ны
өдрийн 250-р тогтоолын хавсралт



№	Компанийн нэр	Регистрийн дугаар	Хүчингүй болгох үйл ажиллагааны чиглэл
1	"АСЕ энд Т капитал ҮЦК" ХХК	5003164	Дилер, андеррайтер
2	"Тэнгэр капитал ҮЦК" ХХК	5157234	Дилер, андеррайтер
3	"Блүмсбюри секьюритиес ҮЦК" ХХК	5139104	Андеррайтер
4	"Эм Ай Би Жи ҮЦК" ХХК	5213487	Андеррайтер
5	"Эф Си Икс ҮЦК" ХХК	5173701	Андеррайтер
6	"Блюскай секьюритиз ҮЦК" ХХК	2057816	Дилер
7	"Батс ҮЦК" ХХК	2027542	Дилер
8	"Зэт Жи Би ҮЦК" ХХК	5469112	Дилер
9	"Өндөрхаан инвест ҮЦК" ХХК	2561077	Дилер
10	"Масдак ҮЦК" ХХК	2786486	Дилер